



“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,
206 тоот өрөө
Утас/факс: 7509-0044
Вэбсайт: www.dmp.mn

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-д шаардлагатай
шууд худалдан авалтын зар **№49**

Төсөвт өртөг: 4,000,000 төгрөг

2026.03.04

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	“Металлыг хий, шингэнээр огтлох, зүсэх чадамж эзэмшүүлэх болон даралтат сав, хийн баллоны аюулгүй ажиллагааны сургалт”	багц	1.0	Өндөр эрсдэлтэй ажлын байр нь ажилтны амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах магадлал бүхий хүчин зүйлс бүхий орчин тул тухайн ажил үүргийг гүйцэтгэх ажилтанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадвар олгож, зохих эрхийг албан ёсоор олгох нь зайлшгүй шаардлагатай. Байгууллагын ажилтнуудад металлыг хий, шингэнээр огтлох, зүсэх ажлын гүйцэтгэлийн ур чадвар эзэмшүүлэх, мөн даралтат сав, хийн баллоны ашиглалт, хадгалалт, аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөх мэдлэг, чадварыг олгох, үйлдвэрлэлийн осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг олгоно.

**“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-иас шууд худалдан авалтаар ажил, үйлчилгээ
гүйцэтгүүлэх тухай ажлын даалгавар**

1. Ерөнхий мэдээлэл

Захиалагч байгууллага: ДТҮ ХХК

Бараа, ажил, үйлчилгээний нэр: “Металлыг хий, шингэнээр огтлох, зүсэх чадамж эзэмшүүлэх
болон даралтат сав, хийн баллоны аюулгүй ажиллагааны сургалт”

2. Худалдан авах үйлчилгээний зорилго

Байгууллагын ажилтнуудад металлыг хий, шингэнээр огтлох, зүсэх ажлын гүйцэтгэлийн ур
чадвар эзэмшүүлэх, мөн даралтат сав, хийн баллоны ашиглалт, хадгалалт, аюулгүй ажиллагааны
шаардлагыг мөрдөх мэдлэг, чадварыг олгох, үйлдвэрлэлийн осол, эрсдэлээс урьдчилан
сэргийлэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

3. Сургалтын хамрах хүрээ, зохион байгуулалт

- Нийт хамрагдах ажилтан: **282 ажилтан**
- Сургалтыг **3 ээлжээр** (хуваан) зохион байгуулна.

- Сургалтын төлбөрийг хүн тус бүрээр тооцохгүй, **цагийн сургалтын үнэлгээгээр тооцож** гүйцэтгэнэ.
- Сургалт нь танхимаар явагдана.
- Сургалтын агуулгад дор дурдсан чиглэлүүдийг заавал тусгана:
 - ✓ Ажлын байрны аюулгүй ажиллагааны дүрэм
 - ✓ Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, зааварчилгаа
 - ✓ Хийн баллонд тавигдах ерөнхий шаардлага, хийн баллоныг өнгөөр ялгах
 - ✓ Хийн баллоныг хадгалах, тээвэрлэх, зөөвөрлөх үеийн аюулгүй ажиллагаа
 - ✓ Тэсэрч дэлбэрэх аюулаас урьдчилан сэргийлэх заавар, дүрэм
 - ✓ Хийн баллоны ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа
 - ✓ КЖГ-16 бензориз багажаар зүсэлт хийх үеийн ХАБЭА-н заавар, дүрэм
 - ✓ Гар аргаар ган материалыг таслах бензин-хүчилтөрөгчийн хийн зүсэлтийн тухай ойлголт
 - ✓ Хийн зүсэлтэд ашиглах хийн төрөл, тэдгээрийн онцлог, хийн баллоны төрөл
 - ✓ Хий, шингэн агуулсан баллонд редуктор угсрах, хийн шланжийг өнгөөр ялгах
 - ✓ КЖГ-16 бензориз багажны техникийн үзүүлэлтүүд, онцлог, ажиллах зарчим
 - ✓ Зүсэгч хошууны налалтын өнцөг тохируулах
 - ✓ Зүсэгдэх металлын төрлөөс хамааруулан хий сонгох, зүсүүрийн хийн дөл тохируулах
 - ✓ Хүчилтөрөгч-бензинээр зүсэх зүсэлтийн технологи, ялгаа, харьцуулалт

4. Гүйцэтгэгчид тавигдах шаардлага ба бүрдүүлэх материал

Сургалтын үйлчилгээ үзүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй байх
2. Холбогдох чиглэлээр сургалт явуулах **тусгай зөвшөөрөлтэй** байх
3. Сургагч багш нь тухайн чиглэлээр **мэргэжлийн болон багшлах эрхийн гэрчилгээтэй** байх
4. Ижил төстэй сургалт зохион байгуулж байсан туршлагатай байх
5. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх
6. Үнийн санал (албан бичгээр, байгууллагын гарын үсэг, тамгатай)

5. Төлбөрийн нөхцөл

- Урьдчилгаа төлбөр олгохгүй.
- Гэрээт ажлын төлбөр болох **100 хувь буюу 4,000,000 төгрөгийг** сургалтын байгууллага гэрээний дагуу бүх ажлыг бүрэн гүйцэтгэж, талууд ажлыг актаар хүлээлцсэний дараа, гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ.

6. Гүйцэтгэх хугацаа

- Гэрээ батлагдсаны дараа гүйцэтгэх хугацааг талууд харилцан тохиролцож тогтооно.
- Захиалагч талаас сургалтын товыг урьдчилан мэдэгдэнэ.
- Гүйцэтгэгч нь товлосон хугацаанд сургалтыг зохион байгуулна.
- Гүйцэтгэх хугацааг тооцохдоо **хуанлийн өдрийг** баримтална.

**Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл**

Шууд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах хаяг:
Худалдан авалтын хэлтэс
/procurement@dmp.mn/
Утас: 7509-0044